

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
1.1 Төслийн нэр.....	5
2.2 Төслийн зорилго.....	5
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	5
Уурхайн дэд бүтэц	7
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
2.1 Төсөл хэрэгжих талбайн физик газарзүйн нөхцөл	9
2.2 Хөрс, хөрсөн бүрхэвч:.....	9
2.3 Ургамлан нөмрөгийн төлөв байдал	10
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	5
БҮЛЭГ 4. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	7
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	9
БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	19
БҮЛЭГ 10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	24
БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	27
БҮЛЭГ 15. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ.....	28

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр

“Цөнхөгийн гол-1”-ийн алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл

2.2 Төслийн зорилго

Төсөл хэрэгжүүлэгч “ЖЕЙ СИ СИ АР” ХХК нь Увс аймгийн Тариалан сумын нутаргт орших “Цөнхөгийн гол - I” амны алтны шороон ордод 2010 оноос олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Монгол Улсын хууль, холбогдох дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр уурхайн ашиглалтыг явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг бүрэн хийх, орон нутагт хүлээлгэн өгөх зэрэгт энэхүү төслийн зорилго оршино.

1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл


Хүснэгт № 1 төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Жей си си ар” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011679003
Регистрийн дугаар	5308488
Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-011809
Хаяг	Улаанбаатар хот, ХУД, 3-р хороо, чингисийн өргөн чөлөө, 49-52 тоот,
Утас	99114660
Цахим шуудан	jeysiar511@gmail.com

Төслийн байршил: Тус талбай нь засаг захиргааны хувьд Увс аймгийн Тариалан сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун хойш 1450 км, Увс аймгийн төв Улаангом хотоос баруун урагш 85 км зайд оршино Төслийн талбайн солбилцолыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт № 2 төслийн ТАЛБАЙН СОЛБИЛЦОЛ

№	Уртраг	Өргөрөг
1	91° 40' 26"	49° 23' 31.74"
2	91° 40' 14.16"	49° 23' 31.74"
3	91° 40' 14.17"	49° 24' 41.75"
4	91° 40' 39.17"	49° 24' 41.75"
5	91° 40' 39.17"	49° 23' 36"
6	91° 40' 26"	49° 23' 36"



Зураг № 1 ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Төслийн хүчин чадал

“Увс аймгийн Тариалан сумын нутагт орших Цөнхөгийн гол - I алтны шороон ордод 2009-2010 гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан” (ордын нөөц 2010,09,01-ны байдлаар) дахь алтны бодитой (B) нөөцийг шлихээр 9,34 кг- аар химийн цэврээр 88.18 кг- аар боломжтой (C) нөөцийг шлихээр 10,99 кг- аар, химийн цэврээр 98,36 кг- аар хүлээн авсан.

Уурхайн ашиглалтын систем

Ордын геологийн тогтоц, хөрсний чулуулгийн шинж чанар, олборлолтын арга, механикжуулалтын бүтэц, тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт зэргийг харгалзан экскаватор-автосамосвалын хослол бүхий автотээвэртэй, дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглана.

Уурхайн ашиглалтын элементүүд

Ашигт малтмалтын давхраасын тогтоц, хөрсний чулуулгийн физик-механикийн шинж чанарыг үндэслэн уурхайн хажуугийн налуугийн өнцгийг 65°-70°-аар тооцов.

Ажлын талбайн хамгийн бага өргөнийг техник аюулгүйн ажиллагааны дүрмийн шаардлагыг хангах хэмжээнд буюу тоног төхөөрөмжийн хэвийн ажиллах байдлыг хангах нөхцөлүүдийг үндэслэн дараах байдлаар тогтоов.

- Доголын ирмэгээс аюулгүйн зурвасын өргөн- 3.0м
- Автомашины тэнхлэгээс дээд доголын хормой хүртэлх зай –3м
- Хөдөлгөөний зурвасуудын тэнхлэг хоорондох зай - 3м

Ажлын талбайн хамгийн бага өргөн: $9.75+3 + 3 + 4.25+ 3 +3= 26\text{м}$ болно. Уурхайд ажиллах үндсэн тоног төхөөрөмжүүд болон хоосон чулуулаг, элсний пластын зузаанаас хамааран доголын өндөр 1.1-7 м байна.

Ашиглалтын технологи, механикжуулалтын бүтэц

Шимт хөрсийг 0.3 метр зузаантай хуулж шимт хөрсний овоолгод хадгалах ба хөрсний чулуулгийг бульдозерын түрэх ашигтай зайд багтаж байгаа хэсгийг ухаж түрэх бөгөөд үлдсэн хөрс болон элсийг экскаватор – автосамосвалын хослолоор ухаж-ачиж тээвэрлэн хөрсний гадаад, дотоод овоолго болон элс угаах талбайд тус тус хураана.

Хүснэгт № 3 Ил уурхайн механикжуулалтын бүтэц

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Авто тээвэртэй ашиглалтын систем	Хөрс хуулалт	- Ухаж түрэх - Ухаж ачих - Тээвэрлэх - Овоолох
	Элс олборлолт	- Ухаж ачих - Тээвэрлэх

Техник технологийн хүчин чадалтай уялдуулан, хайн ашигтай байх үйл ажиллагааны түвшинг хангахуйц нөхцөлийг өмнөө тавьсан иг үзүүлэлтүүдийг сонгож хэрэглэсэн байна.

Нөөцийн хэсэгшлийн үйлдвэрлэлийн хамгийн бага агуулгыг өргөн хэрэглэж буй матик арга хэрэглэн тогтоожээ. Баяжуулалтын технологийн хяналт, шалгалтын сорьцлолтоор металл авалтын хувь-96.4, тухайн ордод тооцсон ашиглалтын үеийн дундаж |ирдлын хувь-02 байгаа нь тогтоогдсон.

Уурхайн дэд бүтэц

Уурхайн барилга, байгууламж

Уурхайн барилга байгууламжид захиргааны байр, ажилчдын болон хоолны байр, агуулах-засварын байр багтана.

Машин техник, тоног төхөөрөмжийн завсар үйлчилгээ

Ил уурхайд жижиг засварын газрыг барьж байгуулна. Уурхайн машин техник, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг өөрийн засварын мэргэжилтнүүд хийж гүйцэтгэнэ. Засварын хэсэгт дугуй засвар, гагнуур, компрессор зэргийг суурилуулна.

Шатах тослох материалын агуулах

Түлш хадгалах зориулалтаар 60 тонны багтаамжтай ган сав 1 ширхэгийг, дизелийн масло болон бусад тос материалыг зориулалтын савтай нь тус тус хадгална. ШТМ-ын гал аюулгүй байдлын шаардлага, норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна.

Цахилгаан хангамж

Уурхайн нийт цахилгааны хэрэглээг 50 кВт болон 160 кВт-ийн чадалтай дизель үүсгэвэрээр хангахаар төлөвлөсөн. Уурхайд бутлан ялгах хэсэг, ил уурхайн гэрэлтүүлэг, хотхоны гэсэн цахилгаан хэрэглэгч байна. Үйлдвэрлэлийн үндсэн цахилгаан хэрэглэгчид нь ил уурхайн хувьд ил уурхайн цахилгаан гэрэлтүүлэг, худгаас ус татах ЭЦВ-8 насос, харин баяжуулах хэсгийн хувьд скрубберт угаах төхөөрөмж, усны насос, гүйцээн баяжуулалт, цахилгаан гэрэлтүүлэг байна. Уурхайн зүүн талд тосгон байрлах бөгөөд тэнд контор, ажилчдын амрах байр, гэрүүд% хоолны гакзар, агуулах зэрэг ахуйн хэрэглээний цахилгаан эрчим хүчээр хангагдана.

Зам харилцаа

Ордын талбайд төвлөрсөн төв суурин газаргүй бөгөөд талбайгаас зүүн хойшоо Увс аймгийн төв Улаангом хот 85 км-т баруун хойш Тариалан сумын 30км-т, зүүн урагш Өмнөговь сумын төв 50км-т, хойшоо “ Хар тарвагатай”-н нүүрсний уурхайн тосгон 16 км-т тус тус байрлана. Эдгээр бүх төвлөрсөн газруудтай шороон замаар холбогдоно.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төсөл хэрэгжих талбайн физик газарзүйн нөхцөл

Их нууруудын хотгорын давтагдашгүй өвөрмөц хэв шинж бүхий далайн төвшнөөс дээш 1100-1600 метр өргөгдсөн газар нутагт оршдог. Тус сумын газар нутгийн онцлог нь 4126 метр өндөр увс нуурын хөвөө орчмоор 800 метр хүрч намсах өндөрлөгийн өөрлөлтөөр нөхцөлдсөн

Далайн түвшинээс дээш 1100-1600 м өргөгдсөн, байгаль цаг уурын эрс тэс уур амьсгалтай Газар хөдлөлийн эрчим 2,5 балл. Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр, мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой.

Газарзүй: Байгалийн мужлалтаар Увс, Хяргас нуурын хотгорын цөлжүү хээр, хуурай хээрийн дэд муж, Ханхөхийн нурууны дундаж өндөр бэлэрхэг уул бүхий хээр, хуурай хээр, ар хажуугийн ойн дэд муж, Монгол Алтайн зүүн хэсгийн /Хархираа, Түргэн/ цулдам уул, хотгор ян сарьдаг, уулын нуга, уулын хээрийн дэд мужид тус тус багтана.

Ордын баруун тал Хархираагийн салбар уулсын, зүүн тал Хяргас нуурын хотгорын баруун бэлийн намхавтар уулсын системд хамрагдах ба хоорондоо Халхаатын тал, хөсөрийн хар нуур зэрэг уулс хоорондын хөндийгөөр тусгаарлагдана.


Төсөл хэрэгжих талбайн байгалийн бүс бүслүүрийн хэв шинжийг ArcGIS 10.5 программ ашиглан зураглахад хээрийн бүсэд хамаарч байна.

2.2 Хөрс, хөрсөн бүрхэвч:

Төсөл хэрэгжих талбай нь Монгол орны хөрс газарзүйн мужлалаар Говийн их мужийн, Монгол алтайн мужийн, Хархираа-Түргэний тойрогт хамаарна. Энэ бүс нутгийн хөрс нь уулын хүрэн хөрс өргөн тархалттай, уулын хажуу бэл, уулс хоорондын хөндий, хотгоруудад төдийгүй 3000м-ийн өндөрт ч тохиолдоно. Тагийн бүслүүрийн доод хилээс эхлэн уулын хуурай хээрийн хүрэн хөрс залгаж, бэл, хормой хүрч, цайвар хүрэн, заримдаа говийн бор хөрсөөр солигдоно. Энэ мужийн хүрэн хөрс чулуу ихтэй, нимгэн үе давхаргатай. Уулсын хоорондох хөндий хотгор дахь зарим нууруудын орчмоор хужир, марз нугын хөрстэй.



УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг №. 1 Ордын хөрсний хэв шинж, төрөл

2.3 Ургамлан нөмрөгийн төлөв байдал

Төсөл хэрэгжих бүс нутаг нь ургамал газарзүйн мужлалаар Бореалын дэд мужийн, Бореалын хошуу, Хээрийн дэд бүсийн (Казахстан)-Алтай- Зүүн гарын дэд хошуу, Увс нуурын тойрогт хамаарна (Камелин, 2010).

Энэ бүс нутаг нь ургамлан бүрхэвчээр тарчиг, ой модгүй нүцгэн, хад чулуурхаг уулс юм. Энд тачир өвслөг ургамал зонхилон тархана. Хяргас нуурын хотгорт тал хээрийн ургамал зонхилох тул малын бэлчээрт тохиромжтой нутаг юм. Голын хөндийд ховроор улиангар, бургас тохиолдоно.

Зураг №. 2 Ордын ургамлын хэв шинж, төрөл

Уур амьсгал: Ордын талбайн баруун тал Хархираагийн салбар уулсын, зүүн тал Хяргас нуурын хотгорын баруун бэлийн намхавтар уулсын системд хамаарагдах ба хоорондоо Халхаатын тал, Хөсөрийн хар нуур зэрэг уулс хоорондын хөндийгөөр тусгаарлагдана.

Хархираагийн салбар уулс нь шовх оройтой огцом хэрчигдэлтэй гуу жалга элбэгтэй 2100-2500 м-ийн үнэмлэхүй өндөртэй. Нуурын хотгорын баруун талын намхавтар уулс нь 1700-2000 м үнэмлэхүй өндөртэй, хэрчигдэлд хүчтэй орсон гуу жалга элбэгтэй мөлгөрдүү оройтой. Талбайн хамгийн өндөр цэг нь Харлаг хар уул 2542 м, хамгийн нам цэг нь Бургастайн голын хөндийн адгийн өндөр дэнж 1632 м юм. Талбай нь эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай богино зунтай, урт өвөлтэй, хамгийн хүйтэн нь 1-р сард -20° -35° , хамгийн халуун нь 7-р сард $+18^{\circ}$ - $(+25^{\circ})$ байх ба жилдээ 100-180 мм хур тунадас унана.Ю-р сарын дунд үеэс 5-р сарын эх хүртэл цасан бүрхүүл тогтоно. 11-р сарын эхээр газар хөлдөж эхлэх бөгөөд хөрсний хөлдөлтийн гүн нь 3 м хүрнэ.

Ордын орчимд усан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн бөгөөд Бургастайн гол түүний цутгалууд Баруун, Зүүн салааны, Хорхойтын, Талын салаа, Шивээн гол, Цагаан усны гол зэрэг байнгын урсгалтай голууд, Үнэгт, Дайв, Хайчийн зэрэг байнгын бус устай сайрууд, Сэрүүний хаг, Хөсөрийн хар нуур, Холбоо нуур зэрэг жижиг шорвог нуурууд байдаг. Нуур гол горхиуд нь ихэвчлэн байгалийн хур бороо гадаргуугийн усаар тэжээгдэх бөгөөд 10-р сарын дунд үеэс хөлдөж 5-р сарын эхээр гэснэ.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс үзвэл төслийн үйл ажиллагаа нь газрын гадарга, газрын гүний геологийн тогтоц, ус, хөрс, ургамалд ихээхэн сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Агаар орчин: Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд:“Цөнхөгийн гол-1” алтны шороон ордыг ил уурхайн аргаар төслийн явцад агаарын чанарт нөлөөлөх үүсгэх эх үүсвэрүүд нь:

- Хөрс хуулах, хүдэр олборлох үед тоос, шороо ихээр үүсгэнэ.
- Уурхайн малталтууд болон овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос, шороо
- Уурхайн машин техникүүдийн түлшний шаталтаас ялгарах утаа, тортог, хорт хийнүүд
- Ажилчдын суурингаас гарах хатуу шингэн хог хаягдлын бохирдол

Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл:

Төслийн хүрээнд хөрс хуулагдах талбай ба хаягдлын болон бусад овоолгуудад дарагдах талбай, барилга байгууламж, тээврийн үам, материалын агуулах байгуулах ажлын үр дүнд талбайн хөрс элэгдэлд орно.

Уурхайн малталт, дотоод үзамууд, барилгын ажил зэрэг үйл ажиллагаанаас гарах тоос, шороо салхинд амархан хийсэж орд орчмын хөрс ургамлын бохирдуулна.

Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл: Унд ахуйн болон баяжуулах хэсэгт газрын доорх усыг ашигласнаар гадаргын болон газрын доорх усны нөөцөд сөргөөр нөлөөлнө. Төсөл хэрэгжүүлэгч “Жей си си ар” ХХК нь “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарын тухай хууль болон тус газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг баримтлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нь зүйтэй. Тус хуулийн журамд:

- 22.2.Усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс тогтооно.
- 22.2.1.онцгой хамгаалалтын бүсэд барилга, байгууламж барих, газар хагалах, газар тариалан эрхлэх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно.
- 22.3.Усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүс тогтооно.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тухайн аймгийн Засаг дарга гэрээ байгуулж, хяналтыг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

- Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлолт явуулсан талбайд нөхөн сэргээлт хийгээгүй тохиолдолд нөхөн сэргээлт хийхэд гаргах зардлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч бүрийн ашиглалт явуулсан хугацаанд олсон орлоготой нь уялдуулан нөхөж гаргуулна."

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл: Төслийн талбайд ил уурхай байгуулах, шимт хөрсний болон хаягдал чулуулгийн овоолго бий болгох, уурхайн зам, дэд бүтцүүдийн барилгын ажил хийгдэх зэрэгтэй холбоотойгоор хөрс хуулалт явагдах ба эдгээр үйл ажиллагаа нь ургамлан нөмрөгт шууд болон шууд бус нөлөөллийг үзүүлнэ. Мөн уурхайн байнгын үйл ажиллагаа ургамлан нөмрөгт дам нөлөөлөл богино ба урт хугацаанд үзүүлсээр байх юм. "Цөнхөгийн гол-1" алтны шороон ордыг ил уурхайн аргаар 2 жилийн хугацаанд ашиглах бөгөөд нийт 8.0 га талбай эвдрэлд орохоор байна. Тус эвдрэлд өртөх талбайд нөхөн сэргээлт хийхдээ Ерхөг-ботууль-шарилжит, ботууль-ерхөг-шарилжит болон Чулуурхаг жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст ба сөөг тарих нь зүйтэй.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл: Уурхайн олборлолт өргөжих, хүний үйл ажиллагааны шууд ба дам нөлөөллөөс тухайн нутгийн экосистем, амьтны аймгийн зүйлийн бүрдэл өөрчлөгдөн зарим нэг зүйлийн тоо толгой цөөрч, тархац нутаг хумигдаж, тархалт байршилд өөрчлөлт гарч болно.

Тухайлбал, уурхайн олборлолт болон зам талбайд хөрс ургамлын хамтаар амьтны аймаг ялангуяа шавьж хорхой үе нугаламгүй амьтад, шавьж идэштэн, хэвлээр явагч амьтад орчны хамт зайлуулагдах, үрэгдэж устах зэргээр тодорхой талбайд тоо толгой цөөрнө. Мөн ордын ойр хавийн зэрлэг хөхтөн амьтдын нүүдэл, хөдөлгөөнд саад болох, махан идэшт амьтдын дэлгэц нутаг тасарч хумигдана. Олборлолтын үйл ажиллагаанаас үүсэж буй хэвийн хэмжээнээс хэтэрсэн дуу чимээ, доргио нь шувуу, хөхтөн амьтанд шууд болон дам нөлөөлдөг. Энэ нөлөөлөл нь томоохон хөхтөн амьтдад шууд нөлөө үзүүлэх ба мэрэгч, шувуу, мөлхөгч, шавьжийн бүлгэмдэлд дам нөлөөлөлтэй. Ер нь амьтдад төслийн үйл ажиллагаанаас шалтгаалсан шууд ба дам хоёр хэлбэрээр нөлөөлөл гарна.

Шууд нөлөөлөл: Олборлолтын талбайд байршиж байгаа шавьж идэштэн, туулай хэлбэртэн, мэрэгч амьтдын нүх, үүр ноохой устаж, амьтад нь зэргэлдээ орших сул орон зайруу дайжна. Гэхдээ төсөл хэрэгжих талбайн амьтны аймгийн хувирал, өөрчлөлт бүс нутгийн хэмжээнд онцгой хохирол хор нөлөө болохгүй.

Дам нөлөө: Амьтан устах, дайжих, орчин тохь байх зэрэг сөрөг өөрчлөлт нөлөөллөөс үүдэн амьтны аймагт дам нөлөө аль нэг хэмжээгээр зайлшгүй гардаг. Жижиг мэрэгчээр хооллодог хөхтөн, шувууд тэжээлээ дагаж тухайн орчноос холдоно. Зэлүүд газар хүн нэвтэрч суурьшин хог хаягдал ихсэж орон байр бий болоход хүнд ойр амьтад (хэрээ, шаазгай, гэрийн хулгана, оронгийн бор шувуу, хадны тагтаа, элээ, золбин нохой, муур) шинээр очиж байршсан төдийгүй энэ нь улам олширно. Энэ бүхэн амьтны орчин өөрчлөгдөх нөхцөл болж буй хэрэг юм.

БҮЛЭГ 4. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр тусгасан.

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилго нь “Жей си си ар” ХХК-ийн алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин болон төслийн ажилчид, ойр орчмын оршин суугчид, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тухайн орчныг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, тус төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд оршино. Энэ хүрээнд:

1. Тус төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар арилгах, нөхөн сэргээх үйл ажиллагааг тусгасан сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө зэргийг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө;
2. Мөн тус төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэнүр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүхий л хугацааны турш хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тус тус боловсруулсан болно.

Ингэхдээ, төсөл хэрэгжүүлэгч тухайн арга хэмжээ бүрийг хэрэгжүүлж болохуйц, бодиттой арга хэмжээг төлөвлөн тусгахыг эрхэм болголоо.

Тус төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, батлагдсан аргачлалыг баримтлан боловсруулсан бөгөөд төслийн үйл ажиллагааны онцлог, байршил зэргээс шалтгаалан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд багтах дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ,

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-1 АЛТНЫ ШОРООН
ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ

нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно. Харин нөхөн сэргээлтийн төлөвлөгөө болон эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг тус тус оруулсан болно.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт **30.350.0** төг зарцуулахаар төсөвлөв. Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг 12 сарын 30-ны дотор холбогдох байгууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

Хүснэгт №. 3 БОМТ-ний зардалын задаргаа

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал /төг/
	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	1.000.0
	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	5.000.0
	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	5.000.0
	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1.000.0
	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1.250.0
	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	600.0
	Удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ	1.000.0
	БОМТ-ыг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	500.0
	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	15.350.0

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт, стандарт
								2024 он	
1	Агаарын чанар								
	Уурхайн олборлолт болон тээврийн Хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: -Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго хийх газар шорооны	Ил уурхай олборлох ажлын үед тоосонцор ихээр үүсэх үед усалгаа хийх	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	Салхи ихтэй үед 7 хоногт 3 удаа, тогтуун үед 2 удаа усалж байх	Агаарын тухай хууль Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008 MNS(ISO)13688:2000 MNS3306:1991 MNS5620:2006 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004 Бензинхөдөлгүүрт MNS 5013:2003
		Уурхайд орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайг тоосны сарнилтай уялдуулан оновчтой байлгах тооцоог хийж мөрдөж ажиллах	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

<p>ажил, -Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох -Тэсэлгээний ажлын үед үүсэх тоосжилт Ажиллагсад болон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх</p>	<p>Хөрс овоолгын гадаргуу, карьерын орчмоос үүсэх нарийн тоосыг агаарт гаргахгүй байх үүднээс тодорхой горимоор чийгшүүлж байх</p>	<p>Үйл ажиллагааны турш</p>	-		-	Ү.А-ны зардлаар	+	<p>Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003</p>
	<p>Хүнд машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмол байлгах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах</p>	<p>Үйл ажиллагааны турш</p>	-		-	Ү.А-ны зардлаар	+	
	<p>Уурхайн ажиллагсад тоосноос хамгаалах хушуувч, амны маск, хүнсний</p>	<p>Үйл ажиллагааны турш</p>	-		-	Ү.А-ны зардлаар	+	

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах сургалт явуулах							
2	Хөрсөн бүрхэвч								
	Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх. Шатах тослох материал, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг	Өнгөн хөрсийг хуулан авах, хадгалах	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	“Газрын тухай” хууль MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
		Уурхайг замыг зөвхөн нэг маршрутаар явуулах хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах								
	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэх, сул шороо бүхий газруудаас тоос босох	Төслийн талбай дахь сул шороо бүхий газруудыг ургамалжуулах, мод бут тарих	Төслийн талбайд	-		-	Нөхөн сэргээх арга хэмжээнд тусгав	+	MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS
3	Усны нөөц, усны чанарт								
	Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг	Ахуйн бохир усыг цэвэршүүлэн ногоон байгууламжийн усалгаанд ашиглах	Төсөл хэрэгжих талбайд	-		-	Ү.а-ны зардлаар	+	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Усны тухай хууль MNS 4288:1995
		Ажилчдын аюулгүй ажиллагааны дүрэмд усыг ариг гамтай хэрэглэх, хамгаалах тухай тусгаж өгөх	Ажилчдад	-		-	Осол эрсдэлийн менежментийн зардалд	+	/ЗГ-ын 2013 оны 326 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	ургамалжилтанд сөргөөр нөлөөлж болзошгүй.	Ажилчдын унд ахуйн усанд ашиглаж байгаа гүний худагаас дээж авч шинжилгээ хийлгэж, усны найрлагыг тодорхойлуулж, ундны усны стандартад нийцэж буйг хянаж байх	Ажилчдын байрны хүрээнд	-		-	Орчны хяналт шинжилгээний зардалд	Сард 1 удаа	
Сав газраас өгсөн саналын хүрээнд									

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		Орлогын гол, Цөнхөгийн гол, Үүрэг нуур зэрэг томоохон нуур гол дагуу Усны нөөцийг хамгаалах, бохирдох хомсдлоос сэргийлэх, ард иргэдийг үер уснаас сэрэмжлүүлсэн хамгаалалтын бүсийн тэмдэгжүүлэлтийн салбар байршуулах	Үйл ажиллагааны зардалд тусгах	-	-	Үйл ажиллагааны туршид	MNS0900:19 92 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ; MNS3935:19 86 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага; MNS3936:19 86 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх;	Орлогын гол, Цөнхөгийн гол, Үүрэг нуур зэрэг томоохон нуур гол дагуу Усны нөөцийг хамгаалах, бохирдох хомсдлоос сэргийлэх, ард иргэдийг үер уснаас сэрэмжлүүлсэн хамгаалалтын бүсийн тэмдэгжүүлэлтийн салбар байршуулах	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Усны тухай хууль MNS 4288:1995 /ЗГ-ын 2013 оны 326 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/
		Бургастай баг болон усны нөөцийг хамгаалах газруудад мод тарьж ойжуулах ажлыг хийж	Үйл ажиллагааны зардалд тусгах	-	-		Бургастай баг болон усны нөөцийг хамгаалах газруудад мод тарьж ойжуулах		Байгаль орчныг хамгаалах тухай хууль Усны тухай хууль MNS 4288:1995

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		хэрэгжүүлэх, ойн төгөл байгуулах					ажлыг хийж хэрэгжүүлэх, ойн төгөл байгуулах		/ЗГ-ын 2013 оны 326 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/
		Багийн хэмжээнд байгаа хашиж хамгаалах шаардлагатай 4-5 булаг шандны эхийг хамгаалж тохижуулах	Үйл ажиллагааны зардалд тусгах	-	-	Үйл ажиллагааны туршид	Багийн хэмжээнд байгаа хашиж хамгаалах шаардлагатай 4-5 булаг шандны эхийг хамгаалж тохижуулах		Байгаль орчныг хамгаалах тухай хууль Усны тухай хууль MNS 4288:1995 /ЗГ-ын 2013 оны 326 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/
		Өвс тэжээлийн фонд байгуулах	Үйл ажиллагааны зардалд тусгах	-	-	Үйл ажиллагааны туршид	Өвс тэжээлийн фонд байгуулах		
		Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор шаардлагатай	Үйл ажиллагааны зардалд тусгах	-	-	Үйл ажиллагааны туршид	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор		Байгаль орчныг хамгаалах тухай хууль

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		газруудад худаг гаргаж уст цэгийн тоог нэмэгдүүлэх					шаардлагатай газруудад худаг гаргаж уст цэгийн тоог нэмэгдүүлэх		Усны тухай хууль MNS 4288:1995 /ЗГ-ын 2013 оны 326 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/
4	Амьтны аймаг, ургамлан нөмрөг								
	Үйл ажиллагаа явуулсантай амьтны нөөц хомсдох, ухсан нүх шуудуунд мал амьтан унахаас сэргийлэх	Уурхайд эргэн тойрон хамгаалалтын тор татаж, мал амьтан орохоос урьдчилан сэргийлэх	Уурхайн хүрээнд	-		-	1.000.0	+	
	Хог хаягдлыг ангилан ялгах хогын сав байршуулах	Хог хаягдалыг ил задгай хаяж хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор амьтад үржих, хордох нөхцөл бүрдүүлэхгүй байх	Уурхайн хог хаягдлын хүрээнд	-		-	Хог хаягдлын менежментийн зардалд	+	Хог хаягдлын тухай хууль 2017 он

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	Уурхайгаас алт агуулсан элс олборлох, хөрс хуулах зэрэг ажлын үед ургамал устгах, дарагдах талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Уурхайн тосгоны эргэн тойронд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Уурхайн тосгоны хүрээнд	-		-	Ү.А-ны зардлаар		
5	Дуу чимээ								
	Нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах	Олборлолтын ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх		-		-	-	+	
Нийт			1.000.0 сая.төг						

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян,төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүй баримт бичиг
	Нөхөн сэргээлтийн ажлын техникийн үе шатанд орд газрыг ашиглаж дууссаны дараа болон ашиглалтын явцад уурхайн чөлөөлөгдсөн орон зайг цаашид аж ахуйн үйл ажиллагаанд үргэлжлүүлэн ашиглах зорилгоор нөхөн сэргээхэд техникийн нөхөн сэргээлтийн гол зорилт юм.	Ашиглалтын зөвшөөрөлтэй талбайд үүсэн 0,2 га талбайд нөхөн сэргээлт хийх	Үйл ажиллагааны дуусмагц	-	-	-	8.000.0	-	“Байгаль орчныг хамгаалах тухай” “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” MNS5915:2008MNS5916:2008 MNS5917:2008
Нийт 5.000.0 сая.төг									

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах жрх зүйн баримт бичиг
1	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар, байгаль орчны хэлтэстэй хамтран ажиллах	Зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээ авах	Төслийн талбайд	-	-	Үйл ажиллагааны зардлаар		“Байгаль орчныг хамгаалах тухай” “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” MNS5915:2008MNS5916:2008 MNS5917:2008
		Зэрлэг ан амьтанд унд ахуйн ахуйн болон бэлчээрийн зориулалттай сэргээгдэх эрчим хүч ашигласан худаг, уст цэг гаргах						
		Булаг, шанд, гол горхи, уст цэгийг хашиж хамгаалах						
2	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тусгай зөвшөөрлийн талбай байршиж байгаа сум, орон нутагт 1000-аас доошгүй мод тарих, өөрийн нэрэмжит ногоон байгууламж бүхий цэцэрлэг байгуулах	Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тусгай зөвшөөрлийн талбай байршиж байгаа сум, орон нутагт 1000-аас доошгүй мод тарих, өөрийн нэрэмжит ногоон байгууламж бүхий цэцэрлэг байгуулах	Төслийн талбайд	500		5.000.0сая.төг	2024 онд	
3		Голын татмын ойжуулалт хийх, ойн зурвас байгуулах	Төслийн талбайд	-	-	Үйл ажиллагааны зардлаар	2024 онд	

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		Усан сан бүхий газарт хамгаалалтын тэмдэг, тэмдэглэгээ, салбар байршуулах							
Нийт 5.000.0 сая. төг									

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал (мян\төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх, арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Нийт ажиллах хугацаанд уурхайн бүх ажилчдад	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		2024 он	Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Төслийн бүхий л үед хэрэгжүүлэх ХХАА-ны гарын авлагатай болох	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		2024 он	
	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох	Ус, элс, шороо, хүрз цэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт	2	500.0		2024 он	
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших		-	500.0		2024 он	
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах		12				
	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх		-				
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах		-				
Эрүүл мэнд	Ажилчдыг ажлын хувцас хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн		Бүх ажилчдад	Ү.А-ны зардлаар		2024 он	

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	хувцас, резинэн хормогч, резинен гутал, бээлий, хамгаалалтын нүдний шил маск) хангах				
	Хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийг нарийвчлан мэргэжлийн байгууллагаар тогтоолгох	Төслийн нийт хугацаанд	Ү.А-ны зардлаар	2024 он	
Нийт зардал (сая.төг)					1.000.0

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Төсөл хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт, стандарт
							2024 он	
Хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдол	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш				300.0	+	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344:2011
Ахуйн хатуу хог хаягдлаар газрын гадарга бохирдох;	Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ.	Төслийн талбайн бүх барилга байгууламжу удад				300.0	+	Хог хаягдлын тухай хууль
Хог хаягдал, ШТМ-ын хаягдал хурын усаар дамжин гүний усыг бохирдуулах	Унд ахуйн усыг лабораторын шинжилгээнд тогтсон хуваарийн дагуу шинжлүүлж байх	Төслийн талбай дахь худгийн усанд				ОХШХ-т тусгасан аар	+	MNS 3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх MNS 0900:2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Стандарт нийцсэн усаар хангах	Ундны усны стандарт хангасаар усаар ажилчдад үйлчлэх	Ундны усны хүрээнд				300.0	+	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлаг түүнд тавигдах шаардлага MNS 0900:2018
Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх харьяа нийтийн үйлчилгээний албатай хог хаягдлын гэрээ хийх	Ахуйн хатуу, шингэн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, ажилчидын бие засах газар болон бохир ус хуримтлуулах цэгийг холбогдох хууль, стандартын шаардлагад нийцүүлэн хүрээлэн буй орчныг бохирдуулахгүй байхаар төлөвлөн шинээр байгуулах, үүссэн шингэн хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах	Ахуйн хаягдлын хүрээнд				200.0	+	Усны тухай хууль, 2012 он Гүний усыг бохирдолоос хамгаалах ерөнхий шаардлагууд. MNS 3342:1982
	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр. Гал тогоонд хортон шавьжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх					150.0		
Нийт								1.250.0 мян.төг

БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж 2024 он	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
---	-----------------------------------	---	-------------------------------	----------------------------	----------------	--------------------------	-----------------------	---

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөрсний бохирдол								
1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 2 удаа дээж авах	Хагас жил тутамд	Жилд 2 удаа	300.0	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1 жил /15.0/ НИЙТ 120,0 /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж - 15.0 төг,	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга
	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох	2 цэгт /Засварын цех, ШТС/	Хагас жил тутамд	Жилд 2 удаа	200.0	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1 жил х 20,0 Нийт 160,0 хүнд металлын шинжилгээ 1 дээж- 20.0 төг/	MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Усны хяналт шинжилгээ								

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбай орчим	Унд ахуйн усыг хангаж буй уснаас	2024 он	Жилд 2 удаа	100.0	40.0*2 удаа х 1жил НИЙТ 80.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3	Усны түвшин усны ундарга нөөц	Ус ашиглалтаас, зарцуулалтаас газар доорх усны горим өөрчлөгдөх	Гүний худгийн ус, Гол	2024 он				
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 2024 ОНЫ ЗАРДЛЫН ДҮН						600.0		

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Харилцсан албан тушаалтан	Тайлбар
			2024он				
			Сар 3	Сар 5	Сар 9		
1	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	+	-	+	ХАБ-ын мэргэжилтэн	БОМТ-нд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.
2	Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардлаар	+	+	+	ХАБ-ын мэргэжилтэн	
3	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр тогтмол хамруулах. Ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, хордлого тайлах хүнс, бэлдмэлээр хангаж байх	Үйл ажиллагааны зардлаар	+	+	+	Уурхайн эмч,	
4	Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах	Үйл ажиллагааны зардлаар	+	+	+	ХАБ-ын мэргэжилтэн	
5	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 ¹ -д заасны дагуу Байгаль орчны аудит хийлгэх	Үйл ажиллагааны зардлаар	+	+	+	ХАБ-ын мэргэжилтэн	
Нийт 1.000.0							

УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦӨНХӨГИЙН ГОЛ-И АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**БҮЛЭГ 15. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН
СУУГЧДАД ТАЙЛАГНАХ**

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
1	БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Увс аймгийн Тариалан сумын ажлын хэсэгт танилцуулах	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумын засаг захиргаанд хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлт	2024 оны 11 сарын 1 дотор	Үйл ажиллагааны зардлаар	Тус уурхайн байгаль орчны мэргэжилтэн	Увс аймгийн тариалан сум
500.0 мян.төг							